



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/64

Мандалговь

“Ньюкомпасс” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/27 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 01 дугаар сарын 18-ны өдрийн А/17 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хүүхдийн паркт тоглоом нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ньюкомпасс” ХХК-тай 90,800,600 (ерэн сая найман зуун мянга зургаан зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Хүүхдийн паркад тоглоом нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ньюкомпасс” ХХК-ний захирал (Р.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ И/ДОРЖБАТ
Л.ДОРЖБАТ

4822150141